



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/98

Сүхбаатар сум

Мал, амьтны сэг зэм цуглуулж устгах,
орчны цэвэрлэгээ халдваргүйтгэл, шилжилт хөдөлгөөнийг
зохицуулах, хяналт тавих арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 7 дугаар зүйлийн 7.3, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тсот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн, малын гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэл болон өвчний улмаас хорогдсон мал, амьтны сэг зэм цуглуулж устгах, бэлчээр бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж, халдваргүйтгэх, мал, амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх, мэдээлэх, хяналт тавих ажлыг шуурхай, чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

1.1 Мал амьтны гоц халдварт, халдварт, халдваргүй, шимэгчлэх өвчин гарах, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян"-ыг нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-нь хооронд олон нийтийг хамруулан шуурхай чанартай зохион байгуулах,

1.2 Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон шаардлагатай бусад зардлыг гамшгийн нөөц сангаас бүрдүүлж, захирамжийн хэрэгжилтийг хангаж, уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулан, тэдний үүсгэл санаачилгыг өрнүүлэн, энэхүү ажлын зорилго, ач холбогдлыг олон нийтэд сурталчилгах,

1.3 Харьяалах нутаг дэвсгэрт (өөрийн аймаг, орон нутаг доторх) отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоох, шилжилт хөдөлгөөн хийх явцад болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулах, устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хяналт тавих,

1.4 Мал эмнэлгийн нэгдсэн системийг орон нутагтаа бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, төсөв хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,

1.5 Дээрх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг сумдын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулан чанартай, шуурхай гүйцэтгэхэд удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах.

2. Мэргэжлийн байгууллагын заавар, удирдамжийн дагуу мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажилд идэвхтэй оролцохыг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай. Үүнд:

2.1 Малын хашаа хороог цэвэрлэх, өтөг, хөрзөнг гадагш гаргаж хураах, механик цэвэрлэгээ бүрэн хийх ажлыг 05 дугаар сарын 15-ны дотоо гүйцэтгэж, халдваргүйтгэл хийхэд бэлэн болгох,

2.2 Өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа мал, амьтны сэг, зэмийг цуглуулан устгах, булах, уст цэг, булаг шандын эхийг цэвэрлэх, хамгаалах ажлыг сумд дахь улсын байцаагчийн хяналтад гэрээт мал эмнэлэг вйлчилгээний нэгжтэй хамтран гүйцэтгэх,

3. Мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих, орон нутагт сарын аян, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-т үүрэг болгосугай.

4. “Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэл”-ийн сарын аян, “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ”-г зохион байгуулах явцад хариуцлагагүй хандсан хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга /Ж.Сайнцог/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ